



МОНГОЛ УЛСЫН  
СОЁЛЫН ЯАМ

14190 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Денверийн гудамж, Соёлын яамны байр  
Утас: 26-56-26. Факс: (976) 51-26-56-26  
И-мэйл: info@moc.gov.mn, Веб сайт: www.moc.gov.mn

*Д.Мөнхсүрэн*

*Зөвлөмжөөр  
хургалсан  
хургалсан  
хургалсан*

*2023.01.04*

№

*10/24*

танай

*М.*

-ны №

-1


ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАРТ

Төсвийн тухай хуулийн 14.2.10-д заасан бүрэх эрхийн хүрээнд Соёлын сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу танай байгууллагын 2022 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын тайланг хүргүүлж байна.

Тайлангаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллана уу.

Хавсралт хуудас.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Чимэдлхам* Б.ЧИМЭДЛХАМ



9020000413 CTC2233 6594204

14190110038

БАТЛАВ  
СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

2022 оны 11 сарын 21 өдөр

## ДОТООД АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

2022 оны 11 сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

### 1. Дотоод аудитын нэр:

“Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газар” -ын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх дотоод аудит.

### 2. Дотоод аудитын код:

ХШУДАГ-2022-11/ДА/СА/-35

### 3. Дотоод аудит хийх нийтлэг үндэслэл

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.26, Соёлын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны 2022 оны төлөвлөгөө”-ний 2.1.6-ийн дагуу дотоод аудитыг гүйцэтгэнэ.

### 4. Дотоод аудитын зорилго

“Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газар” -ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж дүгнэх, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх замаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой.

### 5. Дотоод аудитын хамрах хүрээ

Тус байгууллагын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд дотоод аудитыг гүйцэтгэнэ.

### 6. Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт

Дотоод аудитыг тус байгууллагын Шилэн дансны тухай хуулийн 2022 оны II улирлын хэрэгжилтэд ХШҮДАГ-аас гүйцэтгэсэн дотоод аудитын тайлангийн хамрах хүрээгээр хязгаарлана.

**7. Дотоод аудитыг хэрэгжүүлэх чиглэл**

- Засаглал, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлох, дотоод хяналтын 2022 оны тайлан, баримтыг хянаж үр нөлөөг үнэлэх.
- Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнасан байдлыг тайлангийн тодруулга тайлангуудын уялдаа холбоог үнэлэх, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэхийг үнэлж дүгнэх.
- Батлагдсан орон тооны мөрдөлт, цалин тогтоолт, бодолт, олголт, цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийн тайлагнал, өр авлагыг тулган баталгаажуулж дүгнэх.
- Төрийн өмчийн хөрөнгө, бараа материалын журналын хөтлөлт, орлого, зарлагын баримтын бүрдүүлэлтийг хянах, үндсэн хөрөнгийг хөдлөл өөрчлөлтийг ТӨБЗГ-ын шийдвэрээр үнэн зөв тайлагнасан байдалд хяналт тавих.

**8. Дотоод аудитын төлөвлөгөө**

Дотоод аудитын төлөвлөгөөг **Ажлын баримт 2000**-р үзүүллээ.

**9. Дотоод аудитыг хэрэгжүүлэх хугацаа**

2022 оны ...!!... дүгээр сарын 21-ны өдрөөс эхлэн ажлын 5 хоног

**10. Дотоод аудитын багийн бүрэлдэхүүн**

Дотоод аудитыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чимэдлхам удирдаж, үе шатны болон чанарын хяналт тавьж, дотоод аудит, эрсдэлийн удирдлага хариуцсан шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Б.Лхагвасүрэн нар гүйцэтгэнэ.

Шаардлагатай тохиолдолд аудитын багт нэмэлтээр ХШҮДАГ-ын мэргэжилтэн, гэрээт ажилтныг ажиллуулж болно.

**11. Үүрэг хариуцлага**

Шалгагдагч байгууллага:

- Шаардлагатай мэдээлэл, санхүүгийн баримт материалыг дотоод аудитын ажлын багт шаардсан хугацаанд нотлох баримтын шаардлагыг хангасан хэлбэрээр саадгүй гаргаж өгөх;
- Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд холбогдох программ хангамж, түүний өөрчлөлтийн бүртгэлд нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;
- Дотоод аудитад ирүүлсэн мэдээ, материал, лавлагааны үнэн зөвийг шалгагдагч байгууллагын удирдлага, холбогдох албан хаагчид хариуцна;
- Дотоод аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал, тайлбар өгөх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх, нотлох баримтын шаардлага хангасан байдлаар биелэлтийг гаргаж ирүүлэх;

Дотоод аудитыг тус байгууллагын Шилэн дансны тухай хуулийн 2022 оны II улирлын хэрэгжилтэд ХШҮДАГ-аас гүйцэтгэсэн дотоод аудитын тайлангийн хамрах хүрээгээр хязгаарлана.

**7. Дотоод аудитыг хэрэгжүүлэх чиглэл**

- Засаглал, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлох, дотоод хяналтын 2022 оны тайлан, баримтыг хянаж үр нөлөөг үнэлэх.
- Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнасан байдлыг тайлангийн тодруулга тайлангуудын уялдаа холбоог үнэлэх, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэхийг үнэлж дүгнэх.
- Батлагдсан орон тооны мөрдөлт, цалин тогтоолт, бодолт, олголт, цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийн тайлагнал, өр авлагыг тулган баталгаажуулж дүгнэх.
- Төрийн өмчийн хөрөнгө, бараа материалын журналын хөтлөлт, орлого, зарлагын баримтын бүрдүүлэлтийг хянах, үндсэн хөрөнгийг хөдлөл өөрчлөлтийг ТӨБЗГ-ын шийдвэрээр үнэн зөв тайлагнасан байдалд хяналт тавих.

**8. Дотоод аудитын төлөвлөгөө**

Дотоод аудитын төлөвлөгөөг **Ажлын баримт 2000**-р үзүүлээ.

**9. Дотоод аудитыг хэрэгжүүлэх хугацаа**

2022 оны ...!!... дүгээр сарын 21-ны өдрөөс эхлэн ажлын 5 хоног

**10. Дотоод аудитын багийн бүрэлдэхүүн**

Дотоод аудитыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чимэдлхам удирдаж, үе шатны болон чанарын хяналт тавьж, дотоод аудит, эрсдэлийн удирдлага хариуцсан шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Б.Лхагвасүрэн нар гүйцэтгэнэ.

Шаардлагатай тохиолдолд аудитын багт нэмэлтээр ХШҮДАГ-ын мэргэжилтэн, гэрээт ажилтныг ажиллуулж болно.

**11. Үүрэг хариуцлага**

Шалгагдагч байгууллага:

- Шаардлагатай мэдээлэл, санхүүгийн баримт материалыг дотоод аудитын ажлын багт шаардсан хугацаанд нотлох баримтын шаардлагыг хангасан хэлбэрээр саадгүй гаргаж өгөх;
- Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд холбогдох программ хангамж, түүний өөрчлөлтийн бүртгэлд нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;
- Дотоод аудитад ирүүлсэн мэдээ, материал, лавлагааны үнэн зөвийг шалгагдагч байгууллагын удирдлага, холбогдох албан хаагчид хариуцна;
- Дотоод аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал, тайлбар өгөх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх, нотлох баримтын шаардлага хангасан байдлаар биелэлтийг гаргаж ирүүлэх;

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Санхүүгийн аудит

Хамрагдсан байгууллага: "Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газар"

Шалгалтын тайлангийн код: ХШУДАГ-2022-11/ДА/СА-35

Улаанбаатар хот  
2022 он



## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	1
1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай.....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ .....	3
2.1. Аудитын зорилго:.....	3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт .....	3
2.3. Аудитын арга, аргачлал .....	3
2.4. Өмнөх шалгалтын талаар .....	3
3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ .....	3
3.1. Засаглалын удирдлагын талаар .....	3
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар.....	4
3.3. Дотоод хяналтын талаар.....	4
4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар.....	4
5. АУДИТЫН ҮР ДҮН.....	5
5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 1 асуудал илэрсэн.....	5
5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 3 асуудал илэрсэн.....	6
6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....	8
7. ЗӨВЛӨМЖ.....	8

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
ДА	Дотоод аудит
СА	Санхүүгийн аудит

- Бусад.

Дотоод аудитын баг:

- Дотоод аудитыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах;
- Дотоод аудит хийхдээ шалгагдагч байгууллагад хүндрэл учруулахгүй төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;
- Дотоод аудитын дүрмийг баримтлан, бие даасан, хараат бус байдлаар гүйцэтгэх;
- Дотоод аудитын ажлын явцад шалгагдагч байгууллагын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Дотоод аудитын тайлангийн төслийг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл тайланд саналыг тусгах;
- Дотоод аудитаар өгсөн зөвлөмж, шийдвэрийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- Нотлох баримт гаргуулах;
- Бусад.

**12. Дотоод аудитын дүнг тайлагнах**

- Аудитын тайланг ажлын баримт АБ4000-р бэлтгэж, ХШУДАГ-ын даргаар чанарын хяналт хийлгүүлэх;
- Дотоод аудитын тайланг сайдад танилцуулан, дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн, албажуулах;
- Дотоод аудитын хорооны хурлын үр дүнгээр гаргасан шийдвэр, зөвлөмжийг шалгагдагч талд хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

---oOo---

## 1. ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.26, Соёлын сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны 2022 оны төлөвлөгөө”-ний 2.1.1 дэх хэсэг, Соёлын сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр баталсан “Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газар” -ын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх дотоод аудитын удирдамжийн дагуу 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн ХШУДАГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чимэдлхам мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, үе шатны болон чанарын хяналт тавьж, шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Б.Лхагвасүрэн нар санхүүгийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

### 1.1. Байгууллагын тухай

Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/361 дүгээр захирамжаар Өвөрхангай аймгийн Соёлын хэлтсийг анх байгуулсан.

Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолын дагуу 2022 оны 1 дүгээр сарын 21-ээс “Соёл, урлагийн газар” болон өөрчлөгдөж, 11 хүний орон тоотой ажиллаж байна.

Байгууллагын регистрийн дугаар 3569578, үндсэн үйл ажиллагааны 100-1000-34003, нэмэлт санхүүжилтийн 100-1000-34401 тоот харилцах данснуудаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аудитын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Өсөх-Эрдэнэ 2022 оны 1 дугаар сарын 1-ээс өнөөг хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнгөнзул нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2022 оны хагас жилийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

#### Бүтэц зохион байгуулалт

Соёлын сайдын 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн А/04 дүгээр тушаал, Өвөрхангай аймгийн Засаг даргын А/23 дугаар тушаалаар “Аймгийн Соёл, урлагийн газар”-ыг 2 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 11 байхаар тогтоосон.

Засаглах удирдлага: Байгууллагын дүрмийн 1.6-д газар нь орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байж болох тухай заалтын дагуу даргын дэргэд 4 зөвлөл ажиллаж байна. Үүнд: Гэр бүлийн зөвлөл, Баримт бичиг нягтлан шалгах комисс, Ес зүйн зөвлөл, Дотоод хяналт, шалгалтын нэгж.

Гүйцэтгэх удирдлага: Захиргаа удирдлагыг хэлтэс-1, Соёл урлагийн хэлтэс-1, -11 хүний орон тоотой.



## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

### 2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Аудитын хамрах хүрээг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тус газраас гүйцэтгэсэн дотоод аудитын тайлангийн хамарсан хүрээгээр хязгаарлав.

### 2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

### 2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллага нь 2021 оны 7 дугаар сард шинээр байгуулагдсан, санхүүгийн тайлангийн аудитын шалгалтад хамрагдаагүй болно.

## 3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

### 3.1. Засаглалын удирдлагын талаар

#### Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын даргын 2022 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн А/01 тушаалаар “Соёл, урлагийн газрын дотоод журам”-ыг баталсан байна.

### Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2022 оны хагас жилийн байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 10 “А”, боловсон хүчний чиглэлээр 17 “Б”, нийт 27 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна

### **3.2. Эрсдэлийн удирдлагын талаар**

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

### **3.3. Дотоод хяналтын талаар**

Дотоод хяналтын тухайд байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна.

## **4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны урсгал санхүүжилтэд улсын төсвөөс 211,888.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны эхний хагас жилд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх 106,807.2 мянган төгрөгийн төсвийн эрхийг бүрэн нээж ТЭЗ-ийн төсвөөс бүрэн санхүүжүүлсэн байна.

Эдийн засгийн зардлын ангилал арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны зардал	106,607.2	69,767.4	36,839.8	65.4%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	200.0	0.0	200.0	0.0%
Дүн	106,807.2	69,767.4	37,039.8	65.3%

Тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,302.2 мянган төгрөгөөр буюу 63.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	41,719.8	СОГ 41,719.8

Авлага	-		-
Бараа материал	-	2,418.1	2,418.1
Үндсэн хөрөнгө	-	23,462.8	23,462.8
<b>Нийт хөрөнгө</b>	-	<b>67,600.7</b>	<b>67,600.7</b>
Богино хугацаат өр төлбөр	-	400.4	400.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	67,200.3	67,200.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	-	<b>67,200.3</b>	<b>67,200.3</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 41,719.8 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,418.1 мянган төгрөг байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 9,331.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 6,913.1 мянган төгрөгийн барааг зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 23,462.8 төгрөг бөгөөд энэ нь тайлант хугацаанд 24,939.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 1,477.1 мянган төгрөгийн тайлант хугацааны элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 67,200.3 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Тайлант хугацаанд харилцагч байгууллагад 400.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

## 5. АУДИТЫН ҮР ДҮН

### 5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 1 асуудал илэрсэн.

<b>Илэрсэн асуудал 1.</b> Дотоод хяналт шалгалтын журамгүй, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, албан хаагчдын цалин хөлсийг бүрэн олгоогүй байна.	
Дотоод аудитын хамарсан хүрээ: 1. Засаглал, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	<b>Илэрсэн алдаа, дутагдал:</b>
Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.	<ul style="list-style-type: none"> <li>Дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах журам байхгүй, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй;</li> </ul>
<b>Шалтгаан</b>	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
<b>Үр нөлөө</b>	
Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтгүйгээс эрсдэл үүсэх.	
<b>Дүгнэлт:</b>	
Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.	
<b>Зөвлөмж:</b>	
1. Дотоод хяналт шалгалтын журам боловсруулан, төлөвлөгөөнд тусгасан хяналт шалгалтыг удирдамжийн дагуу гүйцэтгэн, тайлан мэдээг даргад танилцуулан, холбогдох арга хэмжээг авч, үр дүнг хамт олонд мэдээлж байх;	

**5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 3 асуудал илэрсэн.**


<b>Илэрсэн асуудал 2.</b> Санхүүгийн тайлагналын үнэн зөв байдлыг бүрэн хангаж тайлагнаагүй байна.	
Дотоод аудитын чиглэл: 2. Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнасан байдлыг тайлангийн тодруулга тайлангуудын уялдаа холбоогоор үнэлэх, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан эсэхийг үнэлж дүгнэх.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	<b>Илэрсэн алдаа, дутагдал:</b>
<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.2.Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага /Төсвийн байгууллага/ нь Төсвийн тухай хуулийн 26.3-т /Улсын салбар, төсвийн бүртгэлд ашиглах нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандарт/ нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана;</p> <p>Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.4 Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх шаардлагыг хангаагүй;</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Яамнаас олгосон 106.8 сая төгрөгийн төсвийн урсгал санхүүжилтийг “Улсын төвлөрсөн төсвийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт” – эдийн засгийн ангиллаар бүртгэсэн;</li> <li>• Нийгмийн даатгалын байгууллагад төлөх 52.6 мянган төгрөгийн шимтгэлийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй;</li> <li>• Тайлант хугацаанд 92 удаагийн 63,467.4 мянган төгрөгийн цалингийн гүйлгээ, бараа ажил үйлчилгээ худалдан авалтын 17 удаагийн 4,234.2 мянган төгрөгийн зардлын гүйлгээг өглөг, авлагын журналд бүртгэхгүй шууд зардлаар бүртгэсэн;</li> </ul>
<p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ:</p> <p>14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх;</p> <p>Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй;</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Тайлант хугацаанд 6 удаагийн 1,453.2 мянган төгрөгийн зардлын гүйлгээ гаргахдаа е баримтгүйгээр худалдан авалтыг хийсэн;</li> </ul>
<b>Шалтгаан</b>	
Байгууллагын нягтлан бодогчийн санхүү, бүртгэлийн зааврыг буруу хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэл	
<b>Үр нөлөө</b>	
Санхүүгийн тайлангийн санхүүжилтийн орлогын дүн мэдээг буруу илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлан, цаашилбал төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөөх үр дагавартай.	
<b>Дүгнэлт:</b>	
Санхүүгийн тайлангийн орлого, зардал, өглөгийг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн журам, зааврыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.	
<b>Зөвлөмж:</b>	
<ol style="list-style-type: none"> <li>1. Санхүүжилтийн эх үүсвэрийн орлогын эдийн засгийн ангиллыг зөв ангилан бүртгэж залруулга хийх;</li> <li>2. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнах;</li> <li>3. Зардлыг тооцооны дансаар өглөг, авлага үүсгэн бүртгэж хяналтыг сайжруулах;</li> <li>4. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах зардлын гүйлгээний цахим баримтыг бүрэн бүрдүүлж гүйлгээ хийх;</li> </ol>	

<b>Илэрсэн асуудал 3.</b> Төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал үндэслэлгүй олгосон, Хувь хүний орлогын албан татварын тайлангийн мэдээг үнэн зөв гаргаж тайлагнаагүй байна.	
Дотоод аудитын чиглэл: 3. Батлагдсан орон тооны мөрдөлт, цалин тогтоолт, бодолт, олголт, цалингаас суутгасан ХХОАТ, НДШ-ийн тайлагнал, өр авлагыг тулган баталгаажуулж дүгнэх.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	<b>Илэрсэн алдаа, дутагдал:</b>
Төрийн албаны тухай хуулийн 25.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн захиргааны албан тушаалын ангилал зэрэглэлд төрийн мэргэшсэн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй 7 иргэдийг ажиллуулсан, мөн</li> </ul>

<p>хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.</p> <p>Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Шимтгэлийн тайлан буюу ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, шимтгэл тодорхойлох хуудсыг үндэслэн шимтгэлийн тооцоог хийх бөгөөд төлбөрийг бэлэн бус тооцооны журмаар гүйцэтгэнэ.</p> <p>Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.4<sup>1</sup>;</p> <p>Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам”-ын 4.14.1.6, 4.14.2.6;</p>	<p>ажилчдыг төрийн үйлчилгээний албаны цалингийн ангилал, зэрэглэлээр цалинжуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хагас жилийн тайланг холбогдох журмаар батлагдсан илтгэх хуудсаар дүгнээгүй байж 10 албан хаагчид 2,962.6 мянган төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон;</li> <li>• Нийгмийн даатгалын тайлан, цалингийн тооцооллыг тулган шалгахад 5-р сард бодогдсон цалинг 113.0 мянган төгрөгөөр нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан;</li> </ul>
<p><b>Шалтгаан</b></p>	
<p>Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэл тогтоох, урамшуулал олгох, нийгмийн даатгалын тайлан гаргах зэрэг холбогдох зааврыг мөрдөж ажиллаагүй алдаа гарсан үйлдэл, эс үйлдэл;</p>	
<p><b>Үр нөлөө</b></p>	
<p>Төсвийн хөрөнгө үр нөлөөгүй зарцуулагдах, тайлангийн дүн мэдээ буруу илэрхийлэгдэх эрсдэл үүсгэсэн.</p>	
<p><b>Дүгнэлт:</b></p>	
<p>Төрийн албан хаагчдыг цалин хөлс, урамшууллыг үндэслэлгүй олгосон, нийгмийн даатгалын тайлангийн мэдээг үнэн зөв гаргаж тайлагнаагүй байна.</p>	
<p><b>Зөвлөмж:</b></p>	
<ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийн мөрдөж албан хаагчдыг цалинжуулах;</li> <li>2. Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг мөрдөж ажиллах. Журмын дагуу баримтыг бүрдүүлээгүй олгосон урамшууллыг суутган авах;</li> <li>3. Цалингийн дүн мэдээнд нийцүүлэн Нийгмийн даатгалын тайланг гаргаж тайлагнах;</li> </ol>	

<p><b>Илэрсэн асуудал 4.</b> Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, тайлагналыг бүрэн хангаж ажиллаагүй байна.</p>	
<p>Дотоод аудитын чиглэл: 4. Төрийн өмчийн хөрөнгө, бараа материалын журналын хөтлөлт, орлого, зарлагын баримтын бүрдүүлэлтийг хянах, үндсэн хөрөнгийг хөдлөл өөрчлөлтийг ТӨБЗГ-ын шийдвэрээр үнэн зөв тайлагнасан байдалд хяналт тавих.</p>	
<p><b>Шалгуур үзүүлэлт:</b></p> <p>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.2.Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага /Төсвийн байгууллага/ нь Төсвийн тухай хуулийн 26.3-т /Улсын салбар, төсвийн бүртгэлд ашиглах нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандарт/ нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.</p>	<p><b>Илэрсэн алдаа, дутагдал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн хөрөнгө, бараа материалын тайланг баримтын орлого зарлагын дараалалгүйгээр эмх цэгцгүй хяналт тавих боломжгүй байдлаар архивын нэгж бүрдүүлсэн;</li> <li>• Зарим тохиолдолд бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримтгүйгээр бараа материалыг орлого авсан, зарлагын баримтгүйгээр зөвхөн шаардах хуудсаар бараа материалыг зарлагдсан;</li> </ul>
<p><b>Шалтгаан</b></p>	

<sup>1</sup> Журмын 2.4. Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална.



Бараа материал, үндсэн хөрөнгийн тайланг журам, зааврын дагуу бүртгээгүй нягтлан бодогчийн үйлдэл, эс үйлдэл.

**Үр нөлөө**

Нягтлан бодох, санхүүгийн бүртгэлийн тооцоо буруу хөтлөгдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх нөхцөл үүсгэж байна.

**Дүгнэлт:** Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

**Зөвлөмж:**

1. Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг журам, зааварт нийцүүлэн тайлагнаж байх;

**6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

“Өвөрхангай аймгийн Соёл, урлагийн газар”-ын 2022 оны эхний хагас жилийн төсөв санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдлын үр нөлөө, цаашид үүсэх эрсдэлийг үнэлээд төсвийн шууд захирагчийн чиг үүргийг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.

Аудитаар илэрсэн 4,581.4 мянган төгрөгийн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШУДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

**7. ЗӨВЛӨМЖ**

Төсвийн шууд захирагч, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Д.Өсөх-Эрдэнэ танаа

Хугацаа

Зөвлөмж 1. Дотоод хяналт шалгалтын журам боловсруулан, төлөвлөгөөнд тусгасан хяналт шалгалтыг удирдамжийн дагуу гүйцэтгэн, тайлан мэдээг даргад танилцуулан, холбогдох арга хэмжээг авч, үр дүнг хамт олонд мэдээлж байх;

2022 оны 12-р сарын 25-ны дотор

Зөвлөмж 2. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийн мөрдөж албан хаагчдыг цалинжуулах;

Зөвлөмж 3. Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг мөрдөж ажиллах. Журмын дагуу баримтыг бүрдүүлээгүй олгосон урамшууллыг суутган авах;

Нягтлан бодогч Б.Мөнгөнзулд

Зөвлөмж 4. Санхүүжилтийн эх үүсвэрийн орлогын эдийн засгийн ангиллыг зөв ангилах, мөнгөн гүйлгээний тайланд бэлтгэсэн хөрөнгийг зөв бүртгэн залруулга хийх;

Зөвлөмж 5. Цалингийн дүн мэдээг үндэслэн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан мэдээг гаргаж, үүссэн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнах;

2023 оны 01-р сарын 25-ны дотор

Зөвлөмж 6. Зардлыг тооцооны дансаар өглөг, авлага үүсгэн бүртгэж хяналтыг сайжруулах;

Зөвлөмж 7. Бараа, ажил үйлчилгээ худалдан авах зардлын гүйлгээний цахим баримтыг бүрэн бүрдүүлж гүйлгээ хийх;

Зөвлөмж 8. Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг журам, зааварт нийцүүлэн тайлагнаж байх;

СОЁЛЫН ЯАМ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР